



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 06 сарын 12 өдөр

Дугаар А/Н12

Арвайхээр

**Тендерийн гүйцэтгэгчийг сонгох, тендер
хүчингүй болгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 30 дугаар зүйлийн 30.1.1, 32 дугаар зүйлийн 32.1.1, 46 дугаар зүйлийн 46.1.30 дахь заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Аймгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2019 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 68 дугаар дүгнэлтийн дагуу Төрийн байгууллагуудын их завсар, тоног төхөөрөмж /Өвөрхангай/ ажлын 6 дугаар багц Аймгийн төр захиргааны 2 дугаар байрны /Биеийн тамир, спортын газар/ их засвар /Өвөрхангай, Арвайхээр сум/ ажлыг 89314218 (наян есөн сая гурван зуун арван дөрвөн мянга хоёр зуун арван найм) төгрөгөөр Гүнчимэгтэй ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.


2. Гэрээ байгуулан, ажлын явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т даалгасугай.

3. Шалгарсан аж ахуйн нэгж санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн өгөхийг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-т үүрэг болгосугай.

4. Шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй 1 дүгээр багц Багийн Засаг дарга нарыг унаажуулах /Өвөрхангай/, 2 дугаар багц Аймгийн Засаг даргын Тамгын газрын барилгын их засвар, 7 дугаар багц Аймгийн төр захиргааны 3 дугаар байрны /Гэр бүл хүний хөгжлийн төв/ их засвар /Өвөрхангай, Арвайхээр сум/, 9 дүгээр багц Багийн төвийн барилгын тохижилт /Өвөрхангай, Тарагт сум, 6-р баг/ ажлуудыг хүчингүй болгосугай.

5. Дээрх хүчингүй болсон багцуудыг хязгаарлагдмал тендер шалгаруулалтын журмаар дахин зохион байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100632

D:My Doc. Zahiramj. Zasag darga